



НИЙГ ХЭРХЭН ШИЙДЭХ ВЭ?

Оршин суухтай холбоотой
асуудлыг хэрхэн хөөцөлдөх вэ

2020



MINISTERSTVO VNITRA
ČESKÉ REPUBLIKY



Энэхүү төслийг Бүгд Найрамдах Чех Улсын Дотоод хэргийн яамнаас
санхүүжүүлж, "Слово 21" нийгэмлэг хэрэгжүүлж байгаа болно.

ЧЕХ УЛСАД ИРСЭН ДАРУЙДАА БҮРТГҮҮЛЭЭГҮЙ ТОХИОЛДОЛД ЗӨРЧИЛ ГАРГАСАНД ТООЦНО!

Хэзээ: БНЧУ-ын хилээр нэвтэрсэн өдрөөс эхлэн ажлын 3 хоногийн дотор.

Хаана: Гадаадын иргэдийн асуудал эрхэлсэн цагдаагийн газар, хэрэв та удаан хугацаагаар эсвэл байнга оршин суух зөвшөөрөл хүсч байгаа бол БНЧУ-ын Дотоод хэргийн яамны Орогнол, шилжин суурьшилтын газрын салбар, хэлтэст (цаашид „БНЧУ-ын ДХЯ-ны ОШСГ“ гэх) хандана.

Хэрхэн: биечлэн. Таны өмнөөс зочид буудал, оюутны байрнаас бүртгүүлсэн тохиолдолд дахин бүртгүүлэх шаардлагагүй.

УДААН ХУГАЦААГААР ОРШИН СУУХ ЗӨВШӨӨРӨЛ

- ихэвчлэн Чех Улсын нутаг дэвсгэр дээр хүсэлтээ гаргана (сургуульд суралцах, эрдэм шинжилгээний ажил хийх, гэр бүл нэгтгэх, цэнхэр эсвэл ажилтны карт олгуулахыг хүсэх зэрэг зарим тохиолдолд удаан хугацаагаар оршин суух зөвшөөрлийн хүсэлтийг гадаад улсад суугаа БНЧУ-ын ЭСЯ-нд гаргах боломжтой)
- дийлэнх тохиолдолд ижил зорилгоор олгосон удаан хугацааны визтэй уялдуулан олгодог
- ЧУ-д 1 жилээс дээш түр хугацаагаар оршин суух хүсэлтэй, ажилтны карттай тохиолдолд 3 сараас дээш хугацаагаар оршин суух хүсэлтэй гадаадын иргэнд олгодог • цахим үнэмлэх хэлбэрээр олгодог

УДААН ХУГАЦААГААР ОРШИН СУУХ ЗӨВШӨӨРӨЛ АВАХ ХҮСЭЛТ

Хэн хүсэлт гаргах боломжтой вэ?

Удаан хугацааны (90-ээс дээш хоногийн) визтэй, ЧУ-д 1 жилээс дээш хугацаагаар оршин суух хүсэлтэй гуравдагч орны иргэн. Цэнхэр болон ажилтны карт эзэмшигч, гэр бүл нэгтгэх, эрдэм шинжилгээний ажил хийх зорилгоор ирсэн гадаадын иргэдээс бусад тохиолдолд анх виз олгосон зорилгоо өөрчлөхгүй байх шаардлагатай.

Хэзээ: Хүсэлтийг дээд тал нь 120 хоногийн өмнө, доод тал нь визийн хугацаа хүчинтэй байх сүүлийн өдөрт багтаж гаргах шаардлагатай. Хэрэв энэ өдөр нь амралтын болон нийтээр тэмдэглэдэг баярын өдөртэй давхцвал визийн хугацаа хүчинтэй байх сүүлийн өдрийг ажлын дараагийн өдрөөр тооцдог. Хүсэлтийг тэр өдөртөө багтаж БНЧУ-ын ДХЯ-ны ОШСГ-ын салбар хэлтэст гаргасан байх шаардлагатай. Заасан хугацаанд багтаж хүсэлтээ гаргаагүй



тохиолдолд Чех Улсаас гаргах хүртэл арга хэмжээ авна! Хаана: БНЧУ-ын ДХЯ-ны ОШСГ-ын салбар хэлтэст. Зарим тохиолдолд удаан хугацаагаар оршин суух зөвшөөрлийн хүсэлтээ гадаад улсад суугаа БНЧУ-ын ЭСЯ-нд гаргах боломжтой.

Хэрхэн: удаан хугацаагаар оршин суух зөвшөөрлийн хүсэлтийг биечлэн гаргана. Хүсэлт гаргах үйлчилгээний хураамжид 2500,- чех крон, 15 нас хүрээгүй хүүхэд 1000,- чех крон төлнө. Хүсэлтийг зориулалтын албан ёсны маягтыг бөглөж гаргана.

ХҮСЭЛТ ГАРГАХАД ЯМАР МАТЕРИАЛ БҮРДҮҮЛЭХ ВЭ?

Хүсэлтээ том үсгээр гаргацтай бичнэ үү!

1. Гадаад паспорт,
2. 1 хувь цээж зураг,
3. Чех Улсад оршин суух зорилгыг гэрчилсэн бичиг,
4. байрны бичиг (эрдэм шинжилгээний ажил хийх зорилгоор хүсэлт гаргагчдад хамаарахгүй),
5. ЧУ-д санхүүгийн хангалттай эх үүсвэртэй болохоо гэрчилсэн бичиг (хөдөлмөр эрхлэлт, эрдэм шинжилгээний ажил, цэнхэр болон ажилтны карт* авах хүсэгчдэд хамаарахгүй),

6. Чех Улсыг багтаасан гадаадад зорчигчдын эрүүл мэндийн даатгалтай болохыг гэрчилсэн бичиг, шаардлагатай тохиолдолд даатгалын төлбөрийн тасалбар бүрдүүлнэ,
7. насанд хүрээгүй хүүхэд ЧУ-д оршин суух тохиолдолд хүүхдийн хууль ёсны төлөөлөгчийн зөвшөөрөл (эцэг, эхийн аль нэг нь хүүхдийн хамт Чех Улсад амьдрах гэж байгаа, Чех Улсад нэгэнт оршин сууж байгаа насанд хүрээгүй хүүхдэд хамаарахгүй),
8. шаардлагатай тохиолдолд БНЧУ-ын болон харьяат улсынхаа холбогдох байгууллагаас олгосон ял шийтгэлийн тодорхойлолт эсвэл түүнтэй ижил тодорхойлолт,
9. шаардлагатай бол халдварт өвчин тараахаас сэргийлэх нөхцөл болзлыг хангасан тухай тодорхойлолт.

*) Ажилтны болон цэнхэр картны хувьд хөдөлмөрийн гэрээнийн дагуу олгох цалингийн хэмжээ хамгийн багадаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ байх шаардлагыг хангасан байна.

ЧУХАЛ МЭДЭЭЛЭЛ

Оршин суух зөвшөөрөл авах хүсэлт гаргахдаа гадаад паспорт, төрсний гэрчилгээ, гэрлэгсдийн баталгаа, цээж зургийн хамт бүрдүүлэх бусад баримт бичгийг олгосон хугацаа 180 хоногоос хэтрээгүй байна. Гадаад паспортоос бусад материал чех хувилбараар эсвэл чех хэл рүү орчуулсан байх шаардлагатай. Гадаад паспорт, ИГБББ-ийн баримт, тус улсад оршин суух зорилгыг гэрчилсэн баримтыг эх хувиар нь бүрдүүлнэ. Бүх бичиг баримтыг эх хувиар эсвэл баталгаажуулсан хуулбараар бүрдүүлэх шаардлагатай байдгийг анхаарна уу. Гадаад улсын байгууллагаас олгосон бичиг баримтыг чех хэл дээр орчуулж, олгосон улсаас нь хамааран дээд зэргийн баталгаажуулалт (дахин баталгаажуулалт эсвэл апостиль гэрчилгээгээр) хийх шаардлагатай байдаг.

ОРШИН СУУХ ЗОРИЛГЫГ ГЭРЧИЛСЭН БАРИМТ

а) Сургуульд сурах, боловсрол эзэмших, мэргэжлийн сургалт, дамжаанд хамрагдах

- тухайн хичээлийн жилд суралцаж байгаа эсвэл элсэлтийн шалгалтад тэнцэж, сургуульд орсон тухай сургууль эсвэл боловсролын байгууллагын тодорхойлолт

б) Ажилтны карт

- сарын нийт цалингийн хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний үндсэн тарифаас багагүй, долоо хоногийн ажлын цаг 15-аас доошгүй байх нөхцөлтэйгээр дор хаяж 3 сарын хугацаагаар байгуулсан хөдөлмөрийн гэрээ, ажил гүйцэтгэх тухай гэрээ эсвэл хөдөлмөрийн гэрээ байгуулах тухай гэрээ, тухайн ажлыг гүйцэтгэхэд шаардагдах мэргэжлийн ур чадвартай болохыг гэрчилсэн тодорхойлолт (уг ажлын орон тоо нь ажилтны карт эзэмшигч орох боломжтой сул ажлын саналын бүртгэлд бүртгэгдсэн байх шаардлагатай). Дэлгэрэнгүй мэдээллийг www.mpsv.cz/web/cz/-vyhledavani-volnychpracovnich-mist-pro-cizince цахим хуудаснаас үзнэ үү.



- хуульд заасан онцгой тохиолдолд БНЧУ-ын Хөдөлмөрийн товчооноос олгосон хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл

- гадаадын иргэн Хөдөлмөр эрхлэлтийн тухай хуулийн 98-р зүйлийн дагуу хөдөлмөрийн зах зээлд чөлөөтэй орох эрхтэй тохиолдолд дээр дурдсан зүйлд заасан зарим нөхцлийг хангасныг гэрчилсэн баримт Таны ажил олгогч хөдөлмөр зуучлалын төв (агентур) байх тохиолдолд (хөдөлмөр зуучлалын төвийн жагсаалтыг <https://www.uradprace.cz/web/cz/agentury-prace> цахим хуудаснаас үзнэ үү) гадаадын иргэний овог, нэр, өөрчилөхөөс өмнөх (төрөлхи) овог, иргэний харьяалал, төрсөн он, сар, өдөр, төрсөн газар, оршин суугаа хаяг, түр хугацаагаар томилон ажиллуулах үед хийж гүйцэтгэх ажлын төрөл, ажил хийж гүйцэтгэх газар, ажилтныг түрээсээр ажиллуулах этгээдийн нэр, байршил зэрэг мэдээллийг багтаасан баримтыг бүрдүүлэх шаардлагатай.

в) Цэнхэр карт

- сарын эсвэл жилийн нийт цалингийн хэмжээ нь ЧУ-ын жилийн дундаж цалингаас 1,5 дахин багагүй хэмжээтэй, долоо хоногийн ажлын цаг нь хуулийн дагуу байх нөхцөлтэйгээр доод тал нь нэг жилийн хугацаагаар мэргэжлийн өндөр түвшний ур чадвар шаардагдах ажил хийхээр байгуулсан хөдөлмөрийн гэрээ, мэргэжлийн өндөр түвшний болон мэргэжлийн ур чадварыг гэрчилсэн тодорхойлолт (уг ажлын орон тоо нь цэнхэр карт эзэмшигч орох боломжтой сул ажлын саналын бүртгэлд бүртгэгдсэн байх шаардлагатай)

г) Бизнес эрхлэх зорилгоор

- бизнес эрхлэгчид, аж ахуйн нэгжийн бүртгэл эсвэл жагсаалтад бүртгэгдсэн тухай баримт,
- өр төлбөргүй болохыг гэрчлэх тодорхойлолт,
- хэрэв та компанийн гишүүн бол уг компани, хоршоо өргүй болохыг гэрчлэх тодорхойлолт бүрдүүлэх шаардлагатай.



Өргүй болохыг гэрчлэх тодорхойлолт нь материал бүрдүүлэх өдрийн байдлаар 30-аас дээшгүй хоногийн өмнө олгогдсон байна.

Үүнд дараах байгууллагуудаас олгосон тодорхойлолтыг тооцно:

- Гаалийн газар,
- Татварын газар,
- Эрүүл мэндийн даатгалын компани,
- Нийгмийн хангамжийн асуудал эрхэлсэн газрын холбогдох салбар,
- Шаардлагатай тохиолдолд орлогын албан татвар ногдуулалт

д) Гэр бүл нэгтгэх зорилгоор

- гэр бүлийн гишүүн мөн болохыг тодорхойлсон баримт, жишээлбэл төрсний гэрчилгээ эсвэл гэрлэгсдийн баталгааны эх хувь, эцэг, эх/хууль ёсны төлөөлөгчийн зөвшөөрөл.

е) Судалгаа, эрдэм шинжилгээний ажил хийх зорилгоор

- урьсан байгууллагатай байгуулсан гэрээ,
- гадаадын иргэний зочин эрдэмтэн, зочин багшаар ажиллах хугацаа дууссанаас хойш 6 сарын дотор Чех

Улсад оршин суусантай нь холбоотой ямар нэгэн төлбөр тооцооны асуудал илэрвэл уг төлбөр тооцоог барагдуулахад бэлэн байгаа тухай судалгааны байгууллагаас бичгээр гаргасан тодорхойлолт

ё) хөрөнгө оруулалт хийх

- Дэлгэрэнгүй мэдээллийг www.mvcr.cz/cizinci цахим хуудаснаас үзнэ үү.

ж) ажил хайх/бизнес эхлүүлэх

- их, дээд сургуульд амжилттай суралцаж төгссөн тухай баримт
- эрдэм шинжилгээний байгууллагаас олгосон судалгаа хийж дууссан тухай тодорхойлолт

УДААН ХУГАЦААГААР ОРШИН СУУХ ЗӨВШӨӨРӨЛ СУНГУУЛАХ

Хэзээ: Хүсэлтийг дээд тал нь 120 хоногийн өмнө, доод тал нь өмнөх зөвшөөрлийн хугацаа хүчинтэй сүүлийн өдөрт багтаж гаргах шаардлагатай. Хэрэв энэ өдөр нь амралтын болон нийтээр тэмдэглэдэг баярын өдөртэй давхцвал визийн хугацаа хүчинтэй байх сүүлийн өдрийг ажлын дараагийн өдрөөр тооцдог. Хүсэлтийг тэр өдөртөө багтаж БНЧУ-ын ДХЯ-ны ОШСГ-ын салбар хэлтэст гаргасан байх шаардлагатай. Заасан хугацааны сүүлийн өдөрт багтаж хүсэлтээ шуудангаар илгээсэн байх шаардлагатай.

Хаана: БНЧУ-ын ДХЯ-ны ОШСГ-ын салбар хэлтэст.

Хэрхэн: өөрийн биеэр эсвэл бусад замаар (зөв хаягаар баталгаат шуудангаар илгээсэн, итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан). Хүсэлт гаргах үйлчилгээний хураамжид 2500,- чех крон, 15 нас хүрээгүй хүүхэд 1000,- чех крон төлнө.

УДААН ХУГАЦААГААР ОРШИН СУУХ ЗӨВШӨӨРЛӨӨ СУНГУУЛАХ ХҮСЭЛТ ГАРГАХАД ЯМАР МАТЕРИАЛ БҮРДҮҮЛЭХ ВЭ?

1. Гадаад паспорт,
2. Чех Улсад оршин суух зорилгыг гэрчилсэн бичиг,
3. ЧУ-д оршин суух нийт хугацааг хамарсан байрны бичиг (эрдэм шинжилгээний ажил хийх зорилгоор хүсэлт гаргагчдад хамаарахгүй),
4. ЧУ-д санхүүгийн хангалттай эх үүсвэртэй болохоо гэрчилсэн бичиг (эрдэм шинжилгээний ажил, цэнхэр болон ажилтны карт* горилогчдод хамаарахгүй),

5. Чех Улсад эрүүл мэндийн даатгалтай болохыг гэрчилсэн бичиг, шаардлагатай бол даатгалын төлбөрийн тасалбар бүрдүүлнэ (эрдэм шинжилгээний ажил, цэнхэр болон ажилтны карт* горилогчдод хамаарахгүй),
6. нүүр царай өөрчлөгдсөн тохиолдолд 1 хувь цээж зураг.

*) Ажилтны болон цэнхэр карт эзэмшигчдийн хөдөлмөрийн гэрээнд цалин хөлсний асуудалд тавьдаг хамгийн наад захын шаардлага хангасан байна.

ЧУХАЛ МЭДЭЭЛЭЛ

Оршин суух зөвшөөрөл авах хүсэлт гаргахдаа гадаад паспорт, төрсний гэрчилгээ, гэрлэгсдийн баталгаа, цээж зургийн хамт бүрдүүлэх бусад баримт бичгийг олгосон хугацаа 180 хоногоос хэтрээгүй байна. Гадаад паспортоос бусад материал чех хувилбараар эсвэл чех хэл рүү орчуулсан байх шаардлагатай. Гадаад паспорт, ИГБББ-ийн баримт, тус улсад оршин суух зорилгыг гэрчилсэн баримтыг эх хувиар нь бүрдүүлнэ. Бүх бичиг баримтыг эх хувиар эсвэл баталгаажуулсан хуулбараар бүрдүүлэх шаардлагатай байдгийг анхаарна уу. Гадаад улсын байгууллагаас олгосон бичиг баримтыг чех хэл дээр орчуулж, олгосон улсаас нь хамааран дээд зэргийн баталгаажуулалт (дахин баталгаажуулалт эсвэл апостиль гэрчилгээгээр) хийх шаардлагатай байдаг.

ОРШИН СУУХ ЗОРИЛГОО ӨӨРЧЛӨХ

Хэзээ: өмнөх оршин суух зөвшөөрөл хүчинтэй байх хугацаанд.

Хаана: БНЧУ-ын ДХЯ-ны ОШСГ-ын холбогдох салбар хэлтэст.

Хэрхэн: биечлэн. Чех Улсад таван жил амьдарсан тохиолдолд л та оршин суух зөвшөөрлийн зорилгоо “бизнес эрхлэх” зорилго болгон өөрчлөх боломжтой. Энэ нь хөрөнгө оруулалт хийх зорилгоор удаан хугацаагаар оршин суух



зөвшөөрлийн хүсэлт гаргасан болон ажил хайх, бизнес эхлүүлэх зорилгоор удаан хугацаагаар оршин суух зөвшөөрөл авч Чех Улсад амьдарч байгаа гадаадын иргэдэд хамаарахгүй. Хэрэв та тус улсад гэр бүл нэгтгэх зорилгоор удаан хугацааны зөвшөөрлөөр ирсэн бол визийн зорилгоо тус улсад гурван жил амьдарсны хойно эсвэл 18 нас хүрсэн нөхцөлд хийх боломжтой. Ийм хязгаарлал ажилтны эсвэл цэнхэр карттай болох эсвэл оршин суух зорилгоо эрдэм шинжилгээний ажил болгон өөрчлөх тохиолдолд хамаарахгүй.

Хүсэлт гаргах үйлчилгээний хураамжид 2500,- чех крон, 15 нас хүрээгүй хүүхэд 1000,- чех крон төлнө.

БАЙНГА ОРШИН СУУХ ЗӨВШӨӨРӨЛ

- Чех Улсад удаан хугацааны виз эсвэл зөвшөөрлөөр тасралтгүй 5 жил амьдарсан тохиолдолд хүсэлт гаргана
- энэ хугацаанд удаан хугацааны виз, удаан хугацаагаар оршин суух зөвшөөрлийн хугацаа багтдаг
- энэ хугацаанд сургуульд сурах зорилгоор оршин суусан хугацааны хагас нь орно
- байнга оршин суух зөвшөөрөлтэй гадаадын иргэдийн хүүхдүүд Чех Улсад өмнө нь тасралтгүй амьдрах нөхцлийг хангаагүй ч гэр бүл нэгтгэх зорилгоор байнга оршин суух зөвшөөрөл авах хүсэлт гаргах боломжтой
- байнга оршин суух зөвшөөрөл авах хүсэлтээ Чех Улсад БНЧУ-ын ДХЯ-ны ОШСГ-ын холбогдох салбар хэлтэст эсвэл гадаад улсад суугаа БНЧУ-ын ЭСЯ-нд биечлэн гаргана.
- байнга оршин суух зөвшөөрөл олгох асуудлаар шийдвэр гарна
- биеийн давхцахгүй өгөгдөл авахуулсан өдрөөс эхлэн 60 хоногийн дотор цахим үнэмлэхээ очиж авах шаардлагатай
- цахим үнэмлэхийн хүчинтэй хугацааг тодорхой заасан байдаг тул үнэмлэхээ цаг тухайд нь сунгуулахаа мартуузай.

БАЙНГА ОРШИН СУУХ ЗӨВШӨӨРӨЛ АВАХ ХҮСЭЛТ ХҮСЭЛТЭЭ ТОМ ҮСГЭЭР ГАРГАЦТАЙ БИЧНЭ ҮҮ!

Хэзээ: Чех Улсад тасралтгүй 5 жил амьдарсан тохиолдолд гаргана.

Хаана: БНЧУ-ын ДХЯ-ны ОШСГ-ын холбогдох салбар хэлтэст эсвэл гадаад улсад суугаа БНЧУ-ын ЭСЯ-нд.

Хэрхэн: өөрийн биеэр.

Хүсэлт гаргах үйлчилгээний хураамжид 2500,- чех крон, 15 нас хүрээгүй хүүхэд 1000,- чех крон төлнө.

БАЙНГА ОРШИН СУУХ ЗӨВШӨӨРӨЛ АВАХ ХҮСЭЛТ ГАРГАХАД ЯМАР МАТЕРИАЛ БҮРДҮҮЛЭХ ВЭ?

1. Гадаад паспорт,
2. цээж зураг,
3. байрны бичиг,
4. ЧУ-д санхүүгийн хангалттай эх үүсвэртэй болохоо гэрчилсэн бичиг,
5. чех хэлний шалгалтын гэрчилгээ (эхний туршилт үнэгүй!*),
6. гадаад улсад суугаа БНЧУ-ын ЭСЯ-нд гаргасан хүсэлтийн хамт (15-аас доош насны хүүхдэд хамаарахгүй), бусад тохиолдолд холбогдох байгууллагын шаардснаар харьяа улсаас олгосон ял шийтгэлийн тодорхойлолт эсвэл түүнтэй ижил баримт.

*) Чех хэлний шалгалт өгөх эрхийн төлбөргүй бичгийг БНЧУ-ын ДХЯ-ны ОШСГ-ын салбар хэлтсээс авна.

ЧУХАЛ МЭДЭЭЛЭЛ

Оршин суух зөвшөөрөл авах хүсэлт гаргахдаа гадаад паспорт, төрсний гэрчилгээ, гэрлэгсдийн баталгаа, цээж зургийн хамт бүрдүүлэх бусад баримт бичгийг олгосон хугацаа 180 хоногоос хэтрээгүй байна. Гадаад паспортоос бусад материал чех хувилбараар эсвэл чех хэл рүү орчуулсан байх шаардлагатай. Гадаад паспорт, ИГБББ-ийн баримт, тус улсад оршин суух зорилгыг гэрчилсэн баримтыг эх хувиар нь бүрдүүлнэ. Бүх бичиг баримтыг эх хувиар эсвэл баталгаажуулсан хуулбараар бүрдүүлэх шаардлагатай байдгийг анхаарна

уу. Гадаад улсын байгууллагаас олгосон бичиг баримтыг чех хэл дээр орчуулж, олгосон улсаас нь хамааран дээд зэргийн баталгаажуулалт (дахин баталгаажуулалт эсвэл апостиль гэрчилгээгээр) хийх шаардлагатай байдаг.

БАЙНГА ОРШИН СУУХ ЗӨВШӨӨРӨЛ БА ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛ

Та байнга оршин суух зөвшөөрлөө авсан даруйдаа БНЧУ-ын ДХЯ-ны ОШСГ-аас энэ тухайгаа БНЧУ-ын Ерөнхий эрүүл мэндийн даатгалын компанид (ВЗП/ VZP)-д мэдэгдэнэ. Та өөр компанид даатгуулах хүсэлтэй тохиолдолд энэ тухайгаа нэн даруй мэдэгдээгүй бол автоматаар ВЗП (VZP)-д даатгалд хамрагдана. Даатгалын шимтгэлийг заавал төлөх шаардлагатай, шимтгэлийг гадаадын иргэн өөрөө, зарим тохиолдолд даатгуулагчийн өмнөөс улс төлдөг. Хэрэв та хөдөлмөрийн гэрээгээр ажилладаг бол нийтийн даатгалд хамрагдана. Ийм тохиолдолд ч байнга оршин суух зөвшөөрөл авсан тухай эрүүл мэндийн даатгалын компанид мэдэгдэх үүрэгтэй.

ЕХ-НЫ УЛСАД УДААН ХУГАЦААГААР ОРШИН СУУГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ

Чех Улсад тасралтгүй 5 жил амьдарсан, нийгмийн хэв журмыг ноцтой зөрчөөгүй, Чех Улс эсвэл ЕХ-ны өөр улсын аюулгүй байдалд халдаагүй, тус улсад амьдрах санхүүгийн хангалттай эх үүсвэртэй болохоо гэрчилсэн гадаадын иргэнд байнга оршин суух зөвшөөрлийн зэрэгцээ ЕХ-ны улсад удаан хугацаагаар оршин суугчийн эрх зүйн байдлыг олгодог.

Ийм эрх зүйн байдал авснаар ЕХ-ы өөр улс руу нүүх, сургуульд сурах, ажиллах, бизнес эрхлэх хүсэлтэй байвал тухайн улсад удаан хугацаагаар оршин суух зөвшөөрөл авах хүсэлт гаргах боломжтой.

Дэлгэрэнгүй мэдээллийг www.mvcr.cz/cizinci цахим хуудаснаас үзнэ үү.



ӨӨРЧЛӨЛТ ГАРСНЫГ МЭДЭГДЭХ ЖУРАМ

Таны оршин суух зөвшөөрөлтэй холбоотой ямарваа нэгэн өөрчлөлтийг заавал мэдэгдэх үүрэгтэй. Үүргээ биелүүлээгүй тохиолдолд танд торгууль оногдуулж болзошгүй!

Гадаадын иргэний овог нэр, гэр бүлийн байдал, гэрийн хаяг, гадаад паспорт, Чех Улсад оршин суух үнэмлэхэд ямар нэг өөрчлөлт гарсан тохиолдолд тухай бүрд нь ДХЯ-ны Орогнол, шилжин суурьшилтын газрын салбар хэлтэст мэдэгдэх үүрэгтэй.

ГЭРИЙН ХАЯГ ӨӨРЧЛӨГДӨХ

Хэзээ: та удаан хугацааны виз эсвэл удаан хугацаагаар оршин суух зөвшөөрөлтэй ба өөрчлөлт 30 хоногоос дээш хугацаагаар үргэлжлэх тохиолдолд өөрчлөлт гарсан өдрөөс эхлэн хуанлийн 30 хоногийн дотор мэдэгдэх шаардлагатай. Та байнга оршин суух зөвшөөрөлтэй бөгөөд өөрчлөлт 180 хоногоос дээш хугацаагаар үргэлжлэх тохиолдолд өөрчлөлт гарсан өдрөөс эхлэн хуанлийн 30 хоногийн дотор мэдэгдэх шаардлагатай.

Хаана: шинэ хаягийн дагуу харьяалагдах ДХЯ-ны Орогнол, шилжин суурьшилтын газрын салбар хэлтэст.

Хэрхэн: биечлэн эсвэл итгэмжлэлийн дагуу бүрэн эрх олгосон төлөөлөгчөөр төлөөлүүлэн; Байнга оршин суух зөвшөөрөлтэй бол энэ өөрчлөлтийн улмаас танд шинэ цахим үнэмлэх олгох тул биеийн давхцахгүй өгөгдөл авахуулах цагаа захиална уу. Удаан хугацааны оршин суух зөвшөөрөлд гэрийн хаяг бичихгүй тул шинэ цахим үнэмлэх авах шаардлагагүй. Таны гэрийн шинэ хаягийг гадаад паспортод тань бичиж тэмдэглэнэ.

Өөрчлөлт гарсан тухай мэдэгдэхэд ямар материал бүрдүүлэх вэ?

Түрээсийн гэрээний баталгаажуулсан хуулбар эсвэл албан ёсоор баталгаажуулсан гарын үсэг



бүхий байр түрээслүүлэх зөвшөөрөл зэрэг шинэ хаягийн дагуу амьдрах байртай болсныг гэрчлэх бичиг.

Хэрэв та гэрийн хаягаа өөрчилснөө мэдэгдээгүй мөн хуучин хаягаараа оршин суухаа больсон тохиолдолд БНЧУ-ын ДХЯ-ны Орогнол, шилжин суурьшилтын газар таны бүртгэлтэй байгаа хаягийг хүчингүй болгож болзошгүй болохыг анхаарна уу!

Мөн байнга оршин суух зөвшөөрлийн үнэмлэх хуучин өгөгдөл агуулсан гэдэг утгаараа хүчингүй

болж улсын хилээр нэвтрэх үед асуудал үүсч магад. Бүртгэлтэй хаяг хүчингүй болсон ч байнга оршин суух зөвшөөрөл хүчинтэй хэвээр үлдэнэ. Та удаан хугацааны виз эсвэл удаан хугацаагаар оршин суух зөвшөөрөлтэй хэдий ч байрны асуудлаа шийдээгүй тохиолдолд дээрх виз, оршин суух өвшөөрөл хүчингүй болж болзошгүй юм.

ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ ӨӨРЧЛӨГДСӨН ТУХАЙ МЭДЭГДЭХ – ГЭРЛЭЛТ ЭСВЭЛ ГЭРЛЭЛТ ЦУЦЛАЛТ

Хэзээ: өөрчлөлт гарсан өдрөөс эхлэн ажлын 3 хоногийн дотор.

Хаана: оршин суугаа хаягийн дагуу харьяалагдах БНЧУ-ын ДХЯ-ны ОШСГ-ын салбар хэлтэст.

Хэрхэн: биечлэн эсвэл итгэмжлэлийн дагуу бүрэн эрх олгосон төлөөлөгчөөр төлөөлүүлэн.

Өөрчлөлт гарсан тухай мэдэгдэхэд ямар материал бүрдүүлэх вэ?

Гэрлэгсдийн баталгаа, гэрлэлт цуцалсан тухай шүүхийн шийдвэр зэрэг гэр бүлийн байдалд өөрчлөлт гарсныг гэрчилсэн бичиг. Уг бичгийг гадаад улсад олгосон тохиолдолд албан ёсны орчуулга хийлгэж, дээд зэргийн баталгаажуулалт (дахин баталгаажуулалт эсвэл апостиль гэрчилгээгээр) хийлгэх шаардлагатай.

ОВОГ ЭСВЭЛ НЭР ӨӨРЧЛӨГДСӨН ТУХАЙ МЭДЭГДЭХ

Хэзээ: өөрчлөлт гарсан өдрөөс эхлэн ажлын 3 хоногийн дотор.

Хаана: оршин суугаа хаягийн дагуу харьяалагдах БНЧУ-ын ДХЯ-ны ОШСГ-ын салбар хэлтэст.

Хэрхэн: биечлэн эсвэл итгэмжлэлийн дагуу бүрэн эрх олгосон төлөөлөгчөөр төлөөлүүлэн. Өөрчлөлт гарснаас үүдэн танд шинэ цахим үнэмлэх олгох тул биеийн давхцахгүй өгөгдөл авахуулах цагаа захиална уу.

Өөрчлөлт гарсан тухай мэдэгдэхэд ямар материал бүрдүүлэх вэ?

Шинэ нэр эсвэл овог дээр олгосон гадаад паспорт.

ГАДААД ПАСПОРТЫН ӨӨРЧЛӨЛТ

Хэзээ: шинэ гадаад паспорт олгосон эсвэл БНЧУ-д шинэ паспортоор орж ирсэн өдрөөс эхлэн 3 хоногийн дотор.

Хаана: оршин суугаа хаягийн дагуу харьяалагдах БНЧУ-ын ДХЯ-ны Орогнол, шилжин суурьшилтын газрын салбар хэлтэст.

Хэрхэн: биечлэн эсвэл итгэмжлэлийн дагуу бүрэн эрх олгосон төлөөлөгчөөр төлөөлүүлэн.

Өөрчлөлт гарсан тухай мэдэгдэхэд ямар материал бүрдүүлэх вэ?

Шинэ гадаад паспорт.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

МИНИЙ ХҮСЭЛТИЙН ТАЛААР ШИЙДВЭР ГАРСАН ЭСЭХИЙГ ХЭРХЭН МЭДЭЖ БОЛОХ ВЭ?

Таны хүсэлтийг нааштай шийдвэрлэсэн тохиолдолд түүний дугаарыг **www.mvcr.cz/cizinci** цахим хуудсан дээр байрлуулсан жагсаалтаас олж болно. Та өөрөө ДХЯ-ны холбогдох салбар, хэлтэст хандаагүй тохиолдолд тантай холбоо барина. Таны хүсэлтийн талаарх ажиллагааг зогсоосон эсвэл хангаагүй орхисон тохиолдолд БНЧУ-ын ДХЯ-ы ОШСГ-аас шийдвэр бүхий захидлыг зөвхөн таны гарт илгээнэ.

ЦАХИМ ҮНЭМЛЭХИЙГ ХЭРХЭН ОЛГОДОГ ВЭ?

Таны хүсэлт нааштай шийдвэрлэгдсэн тухай мэдэгдлийг цахим хуудас эсвэл БНЧУ-ын ДХЯ-ны ОШСГ-аас авсан даруйдаа биеийн давхцахгүй өгөгдөл буюу нүүрний зураг, гарын хурууны хээ авахуулах цагаа урьдчилан захиална. Биеийн

давхцахгүй өгөгдөл авахуулах явцад үнэмлэх бэлэн болох хугацааг танд мэдэгдэнэ. Үнэмлэхээ БНЧУ-ын ДХЯ-ны Орогнол, шилжин сууршилтын газрын салбар хэлтэст биеийн давхцахгүй өгөгдөл авахуулсан өдрөөс эхлэн 60 хоногийн дотор биечлэн очиж авах хэрэгтэй. Дээрх хугацаанд багтаж үнэмлэхээ аваагүй тохиолдолд оршин суух асуудлаарх ажиллагааг зогсоодгийг анхааралдаа авна уу. ЕХ-ны улсын иргэн, тэдний гэр бүлийн гишүүд удаан хугацаагаар эсвэл байнга оршин суух зөвшөөрлийн шийдвэрээ БНЧУ-ын ДХЯ-ны ОШСГ-ын салбар хэлтэст очиж оршин суух үнэмлэхээ авснаар хүчин төгөлдөр болдог. Гуравдагч орны иргэнд байнга оршин суух зөвшөөрөл олгох шийдвэрийг бичгээр явуулахын зэрэгцээ давж заалдахаас татгалзсан нөхцөлд хүчинтэй болно.

Үнэмлэх олгох хураамжийг улсын тэмдэгтийн марк худалдан авч төлнө.

ГАДААД ПАСПОРТ ЭСВЭЛ ЦАХИМ ҮНЭМЛЭХЭЭ ГЭЭГДҮҮЛСЭН

Гадаад паспорт, цахим үнэмлэхээ гээгдүүлсэн тухайгаа нэн даруй мэдэгдэх шаардлагатай! Эдгээр баримтаа гээгдүүлсэн тухайгаа мэдэгдээгүй явдал зөрчил гаргасанд тооцно.

Хэзээ, хаана: Гадаад паспортоо гээгдүүлсэн тохиолдолд БНЧУ-ын Цагдаагийн газарт нэн даруй, оршин суух зөвшөөрлийн үнэмлэхээ гээгдүүлсэн тохиолдолд БНЧУ-ын ДХЯ-ны Орогнол, шилжин суурьшилтын газрын холбогдох салбар хэлтэст ажлын 3 хоногийн дотор мэдэгдэнэ.

Хэрхэн: биечлэн эсвэл итгэмжлэлийн дагуу бүрэн эрх олгосон төлөөлөгчөөр төлөөлүүлэн. Цахим үнэмлэхээ гээгдүүлсэн тохиолдолд шинэ үнэмлэх авах шаардлагатай тул биеийн давхцахгүй өгөгдөл авахуулах цагаа захиална уу.

ЧЕХ УЛСАД ТӨРСӨН ХҮҮХЭД

Та Чех Улсад хүүхэд төрүүлсэн тохиолдолд хүүхдийнхээ өмнөөс эцэг эсвэл эхийнх нь ижил төрлийн оршин суух зөвшөөрөл авах хүсэлт гаргах шаардлагатай. Чех Улсад төрсөн хүүхдийнхээ өмнөөс оршин суух зөвшөөрөл авах хүсэлт гаргаагүй явдлыг зөрчилд тооцно.

Хэзээ: хүүхэд төрсөн өдрөөс эхлэн 60 хоногийн дотор.

Хаана: БНЧУ-ын ДХЯ-ны Орогнол, шилжин суурьшилтын газрын салбар хэлтэст.

Хэрхэн: биечлэн.

Хүсэлтийн хамт хүүхдийн гадаад паспорт (хүүхдийн хууль ёсны төлөөлөгчийн паспортод хүүхдийн нэр бичигдсэн), төрсний гэрчилгээ, удаан хугацааны виз олгуулах хүсэлт гаргасан тохиолдолд гадаадад зорчигчдын эрүүл мэндийн даатгалын баримт зэргийг бүрдүүлнэ.

ШУУДАН ХҮЛЭЭН АВАХ

Баталгаат шуудангаар танд чухал албан захидал явуулсан тохиолдолд захидал шууданд хадгалагдаж байгаа тухай мэдэгдэл үлдээдэг. Захидал хадгалагдсан өдрөөс эхлэн 10 хоног өнгөрөхөд хэдийгээр та захидлыг гартаа аваагүй ч хүргэсэнд тооцдог. Шуудангийн хайрцаг, гадна хаалганы хонхон дээр нэрээ зөв бичиж байруулах нь шуудан хүргэгч таныг төвөггүй олоход дөхөмтэй.

Шуудангийн хайрцаган дээр нэрээ бичээгүй эсвэл тус хаягаар амьдрахаа больсон зэргээс шалтгаалан шуудан хүргэгчийн гардуулж чадаагүй илгээмжээс ямар үр дагавар гарах вэ?

Оршин суугаа хаягийн дагуу БНЧУ-ын ДХЯ-ны Орогнол, шилжин суурьшилтын газрын салбар хэлтсийн мэдээллийн самбарт (нийтийн зар) болон БНЧУ-ын ДХЯ-ны цахим хуудсанд албан захидал авах боломжтой талаар мэдээнэ. Прага хотод амьдардаг гадаадын иргэд Nad Štolou 3 тоотод байрлах БНЧУ-ын ДХЯ-ны Орогнол, шилжин суурьшилтын газрын салбар хэлтэст хандана.



Албан захидлыг мэдээллийн самбарт тавьсан өдрөөс эхлэн 15 хоног өнгөрөхөд танд хүргүүлсэнд тооцдог болохыг анхаарна уу! Иймд оршин суугаа хаяг өөрчлөгдөх, түрээсийн гэрээний хугацаа сунгах гэх мэт өөрчлөлтийг тухай бүрд нь БНЧУ-ын ДХЯ-ны ОШСГ-т мэдэгдэх шаардлагатай.

ШУУДАНГААР БАРИМТ БИЧИГ ЯВУУЛАХ

Хэрэв та БНЧУ-ын ДХЯ-ны Орогнол, шилжин суурьшилтын газарт баримт бичгээ шуудангаар явуулах тохиолдолд заавал БАТАЛГААТАЙ илгээж маягтыг сайтар хадгалагтун. Шуудангийн маягт захидал явуулсныг гэрчлэх баримт болно. Үүнээс гадна та ШУУДАН ХҮРГЭГДСЭН БАРИМТ үйлчилгээг ашиглаж болох бөгөөд энэ үйлчилгээний давуу тал нь БНЧУ-ын ДХЯ таны захидлыг хүлээн авсныг гэрчлэх баримт өгдөг. Албан байгууллагын хаягийг гаргацтай зөв бичих нь онцгой чухал. Оршин суух зөвшөөрлийн асуудлыг Гадаадын иргэдийн асуудал эрхэлсэн цагдаагийн газар бус БНЧУ-ын ДХЯ-ны Орогнол, шилжин суурьшилтын газар шийдвэрлэдэг. Хүлээн авагчийн хаягийг буруу бичсэн захидлыг шуудан хүлээж авахгүй!

ЗӨВЛӨМЖ

- Чех Улсын нутаг дэвсгэр дээр эрүүл мэндийн даатгалын болон цахим үнэмлэхээ цаг ямагт биедээ авч явах хэрэгтэй.
- Та өөрөө эсвэл төрийн бус байгууллагуудын тусламжтайгаар шийдэж болох асуудлыг бусад этгээдээр хөөцөлдүүлж илүү мөнгө бүү зарцуул.
- Таны итгэл найдварыг бүрэн хүлээсэн хүнд л итгэмжлэл олгож болохыг анхаарна уу!
- Өөрийн биеэр асуудлаа хөөцөлдөж, шийдэхээс бүү ай.
- **www.mvcr.cz/cizinci** цахим хуудсыг сонирхоно уу.